



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Улаанбаатар хот, 14201. Утас: 7019-1087 Факс: 7019-1087
Цахим шуудан: info@police.gov.mn
Цахим хуудас: www.police.gov.mn

2023.04.18 № 087/140

танай _____ ны № _____ -г

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА О.ЦОЛМОН ТАНАА**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг
2023 оны эхний улирлын байдлаар гаргаж, хүргүүлэв.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 9 хуудастай.

ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА _____ П.ОРОСТОГОО



1522 07 1801

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ, БАЙГУУЛЛАГЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

/2023 оны нэгдүгээр улирлын байдлаар/

2023 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагаас 2023 оны нэгдүгээр улиралд байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт, хэрэгжилтийн байдал, тухайн хуулийн хэрэгжилтийг хангах талаар Цагдаагийн ерөнхий газраас авч хэрэгжүүлсэн ажлыг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

Нэг. Мэдээлэл байршуулж байгаа байгууллагын статистик үзүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасны дагуу 2023 оны эхний улирлын байдлаар цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын шилэн дансны нэгдсэн системд хуулийн хугацаанд байршуулбал зохих 15 төрлийн 2,145 мэдээллийг байршуулж, олон нийтэд тайлагнасан, хагас, бүтэн жилээр мэдээлэх хуулийн хугацаа болоогүй 12 төрлийн мэдээлэл байна.

Хүснэгт 1

№	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Хуулийн үйлчлэл
1	Цагдаагийн ерөнхий газар /төсвийн байгууллага/	55	3.1.1
	Нийт	55	

Хоёр. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдал:

Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд 2023 оны эхний улиралд Цагдаа, дотоодын цэргийн 55 байгууллага 55 улирлын тайлан илгээж, тайлан илгээлт 100 хувь, шилэн дансны нэгдсэн цахим системд 2,145 мэдээллийг мэдээлэхээс хугацаандаа мэдээлсэн 2,126, хугацаа хоцроосон 19 мэдээлэл тус тус байршуулсан, огт мэдээлээгүй мэдээлэл байхгүй болно. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдээллийг 99.1 хувийн гүйцэтгэлтэй мэдээлсэн байна. Мэдээллийг бүтцээр нь хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2

№	Мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Хэрэгжилт
1	Сар бүр мэдээлэх	825	807	18	97.8
2	Хагас жилээр мэдээлэх	0	0	0	Хугацаа болоогүй
3	Бүтэн жилээр мэдээлэх	165	164	1	Хугацаа болоогүй
4	Тухай бүр мэдээлэх	1,155	1,155	0	100,0
	Нийт	2,145	2,126	19	99.1

Энэ оны эхний улирлын байдлаар цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл оруулсан, улирлын тайлан илгээлтийн хэрэгжилтийг хүснэгтээр нэгтгэн харуулав.

№	Яам, агентлаг, байгууллагууд	Системд бүртгэлтэй байгууллагын тоо	Тайлан илгээх давтамжийн тоо	Тайлан илгээсэн давтамжийн тоо	Тайлан илгээсэн хувь	Тухайн хугацаанд мэдээлэх давтамжийн тоо	Тухайн хугацаанд мэдээлсэн давтамжийн тоо	Хугацаа хоцроосон мэдээллийн тоо	Мэдээлсэн хувь	Нийт дундаж хувь
1	Цагдаагийн ерөнхий газар	55	55	55	100	2,145	2,126	19	100	99,1

Гурав. Байршуулсан мэдээллийн статистик үзүүлэлт:

Цагдаагийн ерөнхий газар, түүний харъяа байгууллагууд нийт өссөн дүнгээр Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсөв гүйцэтгэлийн 6, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 4, бусад 5 төрлийн мэдээллийг сар бүр, тухай бүр, тухай бүр гэсэн хугацааны давтамжтайгаар байршуулсан байна.

Мэдээлэл байршуулах давтамжийн хугацаагаар тооцож үзэхэд эхний улиралд нэг нэгж 15 төрлийн мэдээг давтамжтайгаар 39 удаа, системийн хэмжээнд нийт 2,145 мэдээллийг байршуулахаас хугацаанд нь 2,126, хугацаа хоцроон байршуулсан 19 мэдээлэл байна.

Энэ оны эхний улиралд цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг хүснэгтээр нэгтгэн харуулав.

1. Мэдээллийн төрөл, байршуулсан хугацаагаар нь ангилсан байдал:

№	Байршуулах мэдээллийн төрөл	Байршуулах мэдээ	Мэдээлсэн	Хугацаандаа	Хоцор сон	Байршуулаагүй мэдээлэл	Хугацаа болоогүй	Хэрэгжилт
1	2	3	4	5	6	7	8	9
1.Төсөв гүйцэтгэл								
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт - эдийн засгийн ангилал (Сар бүр)	165	165	161	4	-	-	97.6
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт - хөтөлбөр зориулалт (Сар бүр)	165	165	157	8	-	-	95.2
3	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (7 хоногийн дотор)	165	165	164	1	-	-	99.4
4	Хандив, тусламжийн орлого (Хагас жилээр)						55	
5	Санхүүгийн тайлан (Хагас жилээр)						55	

6	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Хагас жилээр)						55	
7	Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан (Хагас жилээр)						55	
8	Хандив, тусламжийн орлого (Бүтэн жилээр)						55	
9	Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр)						55	
10	Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр)	55	55	54	1			98.2
11	Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр)						55	
12	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр)						55	
13	Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр)						55	
14	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр)						55	
15	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	165	165	165				100
16	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)	165	165	165				100
	Дүн	880	880	866	14	-		98.4
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт								
1	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Сар бүр)	165	165	162	3	-		98.2
2	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт (Бүтэн жилээр)	55	55	55				100
3	Худалдан авах ажиллагааны тайлан (Бүтэн жилээр)						54	
4	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)	55	55	55				100
5	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)	55	55	55	-	-	-	100
	Дүн	440	440	437	3			99.3
3. Бусад								
1	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр)	165	165	163	2	-	-	98.8
2	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр)					-	55	
3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)	165	165	165				100

4	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)	165	165	165			100
5	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр)	165	165	165			100
6	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр)	165	165	165			100
	Дүн	825	825	823	2		99.5
	НИЙТ ДҮН	2145	2145	2126	19	-	99.1

2. Мэдээллийг нэгж, байршуулсан хугацаагаар нь харуулсан байдал:

№	Нэгжийн нэр	Байршуулах мэдээ	Байршуулсан мэдээ		Хувь
			Хугацаан даа	Хоцорсон	
1	Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газар	39	39	0	100.0
2	Эрүүгийн цагдаагийн алба	39	39	0	100.0
3	Мөрдөн байцаах алба	39	39	0	100.0
4	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны хамгаалалтын газар	39	39	0	100.0
5	Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн алба	39	38	1	97.4
6	Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь цагдаагийн газар	39	39	0	100.0
7	Экологийн цагдаагийн алба	39	39	0	100.0
8	Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн дүн шинжилгээ шуурхай удирдлагын алба	39	39	0	100.0
9	Санхүү аж ахуйн алба	39	39	0	100.0
10	Цагдаагийн ерөнхий газрын Цагдаагийн гэрээт хамгаалалт	39	36	3	92.3
11	Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төв	39	38	1	97.4
12	Цагдаагийн ерөнхий газрын Автобааз	39	39	0	100.0
13	Цагдаагийн алба хаагчдын Сүүж уул сэргээн засах сувилал	39	39	0	100.0
14	ЦЕГ-ын Сургалтын төв	39	39	0	100.0
15	Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулга	39	39	0	100.0
16	Цагдаагийн ерөнхий газрын Хүч спорт хороо	39	39	0	100.0
17	Дотоодын цэргийн штаб	39	39	0	100.0
18	Дотоодын цэргийн 05-р анги	39	39	0	100.0
19	Дотоодын цэргийн 805-р анги	39	39	0	100.0
20	Дотоодын цэргийн 810-р анги	39	35	4	89.7
21	Архангай аймаг дахь Цагдаагийн Газар	39	39	0	100.0
22	Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
23	Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
24	Булган аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
25	Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
26	Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс	39	39	0	100.0

27	Дорнод аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
28	Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
29	Дорноговь аймаг Замын-Үүд дэх СДЦХцагдаагийн хэлтэс	39	38	1	97.4
30	Дундговь аймаг дахь Цагдаагийн газар	39	38	1	97.4
31	Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
32	Завхан аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
33	Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
34	Өвөрхангай аймаг Хархорин сум Цагдаагийн хэлтэс	39	39	0	100.0
35	Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар	39	37	2	94.9
36	Орхон аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
37	Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
38	Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
39	Сэлэнгэ аймаг Мандал сум цагдаагийн хэлтэс	39	39	0	100.0
40	Сэлэнгэ аймаг Сайхан сум цагдаагийн хэлтэс	39	39	0	100.0
41	Төв аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
42	Ховд аймаг Цагдаагийн газар	39	39	0	100.0
43	Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
44	Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар	39	39	0	100.0
45	Увс аймаг дахь цагдаагийн газар	39	39	0	100.0
46	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	39	39	0	100.0
47	Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар	39	39	0	100.0
48	Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар	39	35	4	89.7
49	Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар	39	39	0	100.0
50	Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газар	39	39	0	100.0
51	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газар	39	39	0	100.0
52	Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газар	39	37	2	94.9
53	Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	39	39	0	100
54	Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	39	39	0	100
55	Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс	39	39	0	100
НИЙТ ДҮН		2,145	2,126	19	99.1

**Дөрөв. Цахим хуудасны мэдээлэл байршуулалтад
хяналт тавьсан байдал:**

Цагдаагийн ерөнхий газраас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.5, “Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/ журам”-ын 135.7.4 дэх хэсэгт заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой гарч буй алдаа, зөрчлийг арилгах, сайжруулах зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022, 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.14, 2.4-т заасны

дагуу энэ оны 4 дүгээр сард 2023 оны эхний улирлын байдлаар цахим хуудсанд нэг бүрчлэн тулгалт хийж, хяналт тавьж ажилласан;

2. Цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2022 оны жилийн эцсийн тайлан, мэдээг нэгтгэн, хуулийн хэрэгжилтийг хангах талаар цагдаагийн байгууллагаас хийсэн ажлын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар болон албан бичгээр хуулийн хугацаанд хүргэсэн;

Мөн Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг өөрийн байгууллагын болон www.shilendans.gov.mn гэсэн цахим хуудсанд үнэн зөв, бүрэн мэдээлж, улирлын тайланг хуулийн хугацаанд илгээх талаар болон мэдээлэл байршуулах талаар цахимаар зааварчилгаа өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Шинэчилсэн Шилэн дансны нэгдсэн систем 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэхтэй холбогдуулан шинэ системд цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагад бүртгүүлэх ажлын чиглэл хүргэж, 100 хувь хамруулсан.

Тав. Дүгнэлт:

Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагаас шилэн дансны цахим хуудсанд 2023 оны эхний улирлын байдлаар нийт 2145 мэдээллийг 100 хувь бүрэн байршуулсан бөгөөд хугацаанд нь 2126, хугацаа хоцорч 19 мэдээлэл байршуулсан байна.

Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийг нэгтгэж үзвэл дундаж үзүүлэлтээр **99.1** хувьтай байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хувьд Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүд олон нийтэд 100 хувь мэдээлэгдсэн нь төсвийн ил тод байдал хангагдаж, иргэдээс төсвийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бий болгосон нь уг хуулийн үндсэн зорилтын хэрэгжилт сайн байна гэж дүгнэв.

Зургаа. Санал:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.”-т тусгасан нь ажлын ачаалал нэмэгдүүлэхээр байна.

Иймд зарлагын гүйлгээ хийгдсэн байгууллага бүрд /нэг удаа/ түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаж байх, төсөв захирагч эсвэл ахлах нягтлан бодогч, бусад шийдвэр гаргах албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр дахин мэдэгдлийг гаргуулах саналтай байгааг Танд танилцуулж байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР